



ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	11
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ..	15
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
9. 2022 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	18
10. 2022 ОНЫ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	20
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	20
12. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧ БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	“Түшиг Интернэшнл” ХХК РД: 2714809, ХХД: 9011365136
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн байршил	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 11-р хороо, 85-21 тоот Утас: 99198195
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны орд
2.2	Төслийн байршил	<ul style="list-style-type: none"> ➤ Тус аж ахуй нэгжийн эзэмшиж буй МҮ-018936 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь нийт 28.07 га бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км, Бор-Өндөр өртөөнөөс 5.0 км-т тус тус байрлана.  <ul style="list-style-type: none"> ➤ Газрын байршил нь олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 6 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлагыг хангаж байна.
2.3	Төслийн үндэслэл	<ul style="list-style-type: none"> ➤ “Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-өндөр сумын нутаг “Хүдрийн биет 16-2” нэртэй хайлуур жоншны ордыг Ашигт малтмалын газрын МҮ-018936 тоот тусгай зөвшөөрөл нь 2015 оны 06 сарын 22-ний өдрөөс 2045 оны 06-р сарын 22-г дуустал 30 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. ➤ Ийнхүү тус “Түшиг интернэшнл” ХХК-ийн “Хүдрийн биет 16-2” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах” төслийн эдийн засгийн үндэслэл”-ийг 2017 онд боловсруулан УУЯ, АМГ-н Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулжээ. ➤ Уурхайн төслүүдийн хувьд ЗГ-н 2012 оны 194-р тогтоолоор батлагдсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарын хамгаалалт бүс болон улсын тусгай хамгаалалттай газрын бүс”-д үйл ажиллагаа явуулахыг хориглодог билээ. Тус компанийн эзэмшиж буй МҮ-

		078936А тоот тусгай зөвшөөрлийн талбай нь дээрх бүсүүдэд давхцалгүй болохыг БОАЖЯ-ны ХБОБНУГ-н даргын 2017-12-05-ны №066/7475 тоот лавлагаагаар тодорхойлов.
2.4	Төслийн зорилго	<p>Тус ордыг хүдэр хоршоолох ашиглалтын системийн аргаар нийт 7.1 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн 210.2 мянган тн хүдрийг жилд дунджаар 30.0 мян.тн буюу 11.5 мян.м³ хүдэр олборлож хайлуур жоншны 92%, 85%, 75% бага агуулга бүхий металлургийн болон бүхэллэг хэсгийн ялган боловсруулж экспортлоно.</p> <p>Тус компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хайлуур жоншны ордын талбайн төсөл хэрэгжиж эхэлснээр:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 96 хүнийг тогтмол ажлын байр бий болох. /Орон нутгаас 70% хүний нөөц бүрдэх/ ➤ Хайлуур жонш экспортлох үйл ажиллагаа, ачаа тээврийн хурд нэмэгдэнэ. ➤ Орд ашиглалтын хугацаанд улс болон орон нутгийн төсөвд нийт 5 тэрбум 927.0 сая тегрегийг татвар, телбер хураамж хэлбэрээр төвлөрүүлнэ. ➤ Ойролцоох сумдын эдийн засгийн амьжиргаа болон дэд бүтцийн хувьд хувь нэмэр оруулах зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.
2.5	Төслийн ерөнхий төлөвлөгөө	<p>Үйлдвэрийн барилга байгууламж буюу 4.271 га талбайд баригдсан барилгууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 8 м өндөр уурхайн цамхаг – төмөр 2ш 2. Өргөх машины барилга – Модон барилга 3. Компрессорын барилга – Сендвичин барилга 4. Уурхайн контор –Сендвичин барилга 5. Ахуй үйлчилгээний барилга – тоосгон 6. Шатах тослох материалын агуулах – 20 м³–ын ёмкость
2.5	Төслийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> ✚ Тус ордыг хүдэр хоршоолох ашиглалтын системийн аргаар нийт 7.1 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн 210.2 мянган тн хүдрийг жилд дунджаар 30.0 мян.тн буюу 11.5 мян.м³ хүдэр олборлож хайлуур жоншны 92%, 85%, 75% бага агуулга бүхий металлургийн болон бүхэллэг хэсгийн ялган боловсруулж экспортлоно. Хоногийн хүчин чадал 30000:220=136.4 тн байна. Ээлжинд 45.5 тн, цагт 5.7 тн хүдэр гаргана. ✚ Төслийн багт орон тооны 96 ажилтантай ба 2 ширхэг HOWO байна. ✚ Тус байгууллага нь хүний нөөцийн баг болон техник, технологийн нөөц баазыг хангалттай хэмжээнд бүрдүүлж

		<p>чадсан бөгөөд байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүч, байнгын ажлын байртай албан хаагч, тэдгээрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, нийгмийн хангамжийн асуудлыг бүрэн шийдсэн кемп, засвар үйлчилгээний цэгийг барьж байгуулахаар төлөвлөж байна.</p>
2.6	Төслийн хог хаягдал	<p>Хатуу хог хаягдал:</p> <p>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор нийт 96 ажилтан /жилд ажлын 220хоног Тус төслийн багт 96 хүн ажиллах ба хоногт 1 хүн дунджаар 0,3 кг хатуу хог хаягдал гаргана гэж тооцвол: /жилд ажлын 220хоног/</p> <ul style="list-style-type: none"> • хоногт $96 \times 0,3 = 28.8$ кг • сард $28.8 \text{ кг} \times 30 \text{ хоног} = 864$ кг буюу 0.86 тн • жилд $220 \times 864 \text{ кг} = 190\,080$ кг буюу 190 тн <p>Нийт – 190 тн/жилд хатуу хог ялгарахаар тооцоолов.</p> <p>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгах шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> ✚ Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт ✚ Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд ✚ Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна. <p><i>Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай</i></p>  <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Ахуйн шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт нэг ажилтан зөврөөр хангагддаг тохиолдолд усны нормын дагуу өдөрт 30 литр бөгөөд нийт 96 ажилтан хоногт 2.88 м^3 ус ашиглах ба усалгаанд 6000 м^2 зам талбайг услана гэж үзвэл хоногт 12.0 м^3, жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 220 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 14.88 м^3/хоног, үүнээс ахуйн хэрэгцээний 70%-ийг хаягдал ус гэж үзвэл 10.4 м^3/хон дахин ашиглах болно.</p> <p>Тиймээс төслөөс гарсан бохир усыг зөврийн аргаар 5 тонны</p>

		<p>багтаамж даац бүхий зориулалтын машинаар соруулна. “МҮТТ” ХХК-ийн дотоодод үйлдвэрлэж байгаа бохир ус агуулах 50м³ ын бохирын танк (бохироо соруулах худагт таг, агааржуулалтын хоолойтой сэт) –ыг суурилалтын ажлыг мэргэжлийн компаниар хийлгүүлж, газрын хэвлийд хөлдөлтийн түвшингээс доор 4-5 метрт байгуулж ашиглахыг санал болгов.</p> <p>Бохир ус агуулах ёонкс ба зөөврийн бохир соруулах машин</p>  <p>Хийн хаягдал:</p> <p>Төслийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.</p> <p>Төслийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 1481.7 тн /жилд 493.9 тн/ дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, СО-0.000148 тн, нүүрстөрөгч-0.000445 тн, NO₂-0.00005927 тн, SO₂-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна.</p> <p><i>/Мэргэжлийн хяналтын агаарын хяналт шинжилгээ хийлгэж байх шаардлагатай./</i></p> <p>Аюултай хог хаягдал</p> <p>Харин тослох материал нь химийн гаралтай шингэн хаягдал болон хөрс бохирдуулагч эх үүсвэр болдог тул ийм төрлийн хаягдлыг өндөр температурт шатааж устгадаг технологийг ашиглан устгах, эсвэл ажилласан тос, аккумулятор болон хаягдал дугуй дахин боловсруулдаг үйлдвэрт /Оргил Баялаг Мандах ХХК/ нийлүүлэхийг зөвлөж байна. <i>/Хавсралтаар хамтран ажиллах гэрээ хавсаргав/</i>. Ашигласан тос, масло материалыг зориулалтын хамгаалалт бүхий нөөцийн 1 тн-ийн зориулалтын саванд хийж хураан хүргэж өгөх шаардлагатай.</p>
2.7	Ариун цэврийн байгууламж	<p>Төслийн талбайн ажилчдын сэндвичэн байран дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламж байгуулах бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулах ба экологийн боловсролын булан бий болгосон</p> 

2.8	Усан хангамж	<p>✚ Төслийн газрын цэвэр усны хангамжийг гүний худгаас хангана. Гэрээт Бор-Өндөрийн худаг нь төслийн байрнаас 5 км зайтай байрладаг бөгөөд эрүүл ахуйн бүсийн шаардлага хангаж байна.</p> <p>✚ Хүдрийн биетийг хүдрийг үйлдвэрийн аргаар баяжуулахгүйгээр зөвхөн гар аргаар ангилан ялгах чиглэлээр хүдрийг боловсруулж гаргах учраас уурхайд үйлдвэрлэлийн зорилгоор ус бага хэрэглэх бөгөөд зам талбай усалгаанд 12.0 м3/хон усыг уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглах, ахуйн хэрэгцээний усыг гүний худгаас зөөврөөр хангана. /Усны боломжит нөөцийн дүгнэлт болон 2018 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 1/537 тоот албан тоот болон Бор-Өндөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Бор Өндөр сумын ус дамжуулах өргөлтийн станцаас ахуйн ундны ус ашиглахыг зөвшөөрсөн албан тоот хавсаргав/</p> <p>Унд ахуйн зориулалтаар эхний 2 жилд 99.0м3, 3-7 дахь жилд 633.6м3 ус ашиглах тооцоо гарч байна.</p> <table border="1" data-bbox="531 846 1492 920"> <thead> <tr> <th>№</th> <th>Уртраг</th> <th>Өргөрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Худгийн координат</td> <td>109 24 41.59</td> <td>46 15 39.3</td> </tr> </tbody> </table>	№	Уртраг	Өргөрөг	Худгийн координат	109 24 41.59	46 15 39.3
№	Уртраг	Өргөрөг						
Худгийн координат	109 24 41.59	46 15 39.3						
2.9	Цахилгаан хангамж	<ul style="list-style-type: none"> ➢ Тус бүс нутаг нь эрчим хүчний хувьд сайн хөгжсөн бүсэд оршдог. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумаас Дархан сум хүртэл 35кВт-ын өндөр хүчдэлийн агаарын шугамаар холбогдсон. ➢ “Хүдрийн биет 16-2” жоншны орд нь Бор-Өндөр сумаас Дархан сумдыг холбосон агаарын цахилгаан дамжуулах шугамын 16-р шонгоос агаарын шугам 0.5 км-т татаж ТМН1000/6 трансформаторын дэд станц байгуулан энэ станцаас 500м, 6кВ-ын агаарын шугамыг 2014 онд ашиглалтад өгсөн үүнийг тусгалаа. ➢ Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхлэж, цахилгааны утас татах, холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлсэн байна. 						
2.10	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none"> - Тус байгууламж нь ахуйн усны хэрэглээний халаалтад эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем буюу усан бойлерыг хэрэглэнэ. - Өвлийн цагт ажилчдын байр халаалтад нам даралтын зууханд нүүрс ашиглана. 						
2.11	Гадаад тээвэр	<ul style="list-style-type: none"> ➢ Хайлуур жоншны уурхай нь эцсийн бүтээгдэхүүнээ уурхайгаас 5 км зайд байрлах Бор-Өндөр өртөө хүртэл тээвэрлэнэ. Тус ордын тусгай зөвшөөрлийн талбайгаас Бор-Өндөр хатуу хучилттай зам хүртэл 1.30 км орчим шороон замаар тээвэрлэдэг. 						



Үйлдвэрлэлийн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг төслийн даалгаврын дагуу жилд 30000 тн хүдэр олборлон, баяжуулахаар тооцсон болно.

Хоногийн хүчин чадал $30000:220=136.4$ тн байна. Ээлжинд 45.5 тн, цагт 5.7 тн хүдэр гаргана.

Үйлдвэрийн ажиллах горим

Уурхайн хүчин чадал ажиллах хугацааг харгалзан тооцож, жилд ажиллах хоногийг дараах байдлаар тооцож гаргав. Уурхай нь бүтэн жилийн турш хөдөлмөрийн хуулийн дагуу 7 хоногт 5 ажлын өдөр, хоногт 3 ээлжтэй бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг, газрын дээрх ажилчдад 8 цагаар тогтоосон горимоор ажиллана.

Хүснэгт 1. Үйлдвэрийн ажиллах хоног

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Далд уурхайд	Газрын дээр
1	Календарь хоног	хоног	365	365
2	Баяр ёслол	хоног	11	11
3	Амралт	хоног	104	104
4	Засвар үйлчилгээ	хоног	24	24
4	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	6	6
4	Уурхайн цэвэр ажлын хоног	хоног	220	220
5	Хоногийн ээлжийн тоо	-	3	3

6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	7	8
7	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0,8	0,8
8	Уурхайн хоногт ажиллах бодит цаг	цаг	16,8	19,2
9	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	3696	4224

Уурхайн ашиглалтын хугацаа

Уурхайн ашиглалтын хугацаа нь 7 жил байх ба 1 дэх жилд нь уурхайг байгуулах, нээх 6, 7 дахь жилд нь уурхайн хаалт нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөлөө.

Ордыг нээх ба ашиглах дараалал

Ашигт малтмалын МУ-018936 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хүдрийн биет 16-2” нэртэй 28.07 га талбайд өмнөх хайгуулын үед тогтоогдсон (XV шугамаас XVII шугам хүртэлх) хүдрийн биет хамаарагддаг. Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд багтаж буй хүдрийн биет нь газрын гадарга дээр 170 метр урттай 4.55 метрийн дундаж зузаантай 1 хүдрийн биет илэрдэг бөгөөд 1984 оны өрөмдлөг болон бидний малтсан хэвтээ малталтын үр дүнгээс харахад хүдрийн биет нь 1305 метрийн түвшингээс (газрын гадаргаас 26 м-ын гүнд) доош 2 зэрэгцээ хүдрийн биет болон тогтсон байдаг.



Зураг 1. Уурхайн гол босоо ам

2010-2012 онд хайгуулын нөөцийг тодотгох явцад хийсэн шурф малталтыг уурхайн үндсэн босоо ам ствол №1 ба №2 болгон төлөвлөж 70м болон 74 м гүн нэвтэрсэн. Эдгээрээс босоо амнуудад 30м 50м 70м түвшинт хэвтээ нэвтрэлт хийгдсэн. Хүдрийн судлын зүүн баруун хойш чиглэсэн жигүүрийн дагуу хэвтээ малталтыг 100 м нэвтэрч байна.

Ордыг ашиглах дараалал

Ордыг төв хэсэгт нь нээх тул ашиглах дараалал нь төвөөс 2 жигүүр рүү гэсэн байдалтай байна. Блокийг олборлож байх явцад дараа дараагийн бэлтгэл ажлууд хийгдсэн байх ёстой. Блокийг олборлож байхад дараагийн блокуудад хийгдэх ажил нь блокийг бэлтгэх, блокийг нээх ажлууд зэрэг явагдаж байна. Өөрөөр хэлбэл блокийг олборлож дуусахад тасралтгүй буюу цикл ажиллагааг алдагдуулахгүйн үүднээс дараагийн ажил явагдах блок бэлтгэгдсэн байна.

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны ордын бодит нөөц нь 237.9 мян.тн үүнээс үйлдвэрлэлийн 210.4 мян.тн хүдрийг хоршоолсон системээр блоклон ашиглах боломжтой гэж үзээд техник эдийн засгийн үндэслэлд жилд 30.0 мян.тн хүдэр олборлохоор тусгасан байна.

Баяжуулах хэсэг

Тус талбай дахь хүдрийн биет нь суналын хэмжээнд газрын гадаргууд сайн илэрч гарсан бөгөөд орчин үеийн рельефийн хувьд хэвийн хотгор гүдгэргүй талархуу юм. Хүдрийн биетийн урт-185 м, дундаж зузаан 2.48 м, суналын чиг БХ 337⁰, уналын өнцөг 65⁰-80⁰, гүндээ 140-220 м үргэлжилнэ.

Хүдрийн биетийн геологийн тогтоц болон уул-техникийн нөхцөлүүд нь ордыг далд аргаар хоршоолсон ашиглалтын системээр ашиглахад боломжтойг харуулж байна.

Ашиглалтын системийн сонголт

“Хүдрийн биет 16-2” судал нь “Монголросцветмет” ХХК-ний Бор-Өндөрийн баяжуулах үйлдвэрийн ойролцоо байгаа нь тухайн ордын баяжуулалтын арга технологи, баяжиц зэрэг сайн судлагдсан.

Ийм ч учраас энэ ойр хавийн орд, нэгэн ижил тархацийн энгийн бүтэц бүрэлдэхүүнтэй, дан флюорит юм уу кварц-флюоритын найрлагатай, янз бүрийн настай интрузив, эффүзив, тунамал метасорф чулуулагт хагарлын бүсийг дагасан дүүргэлтийн судлууд голчлон тогтсон байдаг.

“Хүдрийн биет 16-2” биетийн хайлуур жоншны хүдэр дээр 2010 онд Уул уурхайн төсөл судалгааны “Конрес” ХХК лабораторид “Технологийн туршилт” хийлгэсэн.

Хайлуур жоншны хүдэрт агуулагдах СаF₂-ийн агуулга маш өргөн хүрээнд хэлбэлздэг бөгөөд уг агуулгаас нь хамааруулан хүдрийг нь баян (50%-с дээш), дунд зэргийн (35-50%), ердийн (35% хүртэл) гэж ангилдаг. “Хүдрийн биет 16-2” ордын хувьд агуулга дунд зэрэг (40.5%), нөөц багатай бөгөөд хүдрийн бүхэллэгээр нь гараар ялгалт хийн баяжуулах аргыг голчлон сонгон агуулга багатай хүдрээ ойр хавийн флотацийн технологийг ашиглан баяжуулдаг бусад үйлдвэрт зарах боломжтойг харуулж байна.

Гараар ялгах арга: Ашигт эрдэс болон хоосон чулуулгийг өнгө, гялга, хэлбэр дүрсээр нь таньж ялгах процесс юм. Баяжуулалтын бусад аргыг ашиглах боломжгүй нөхцөлд болон баяжмалын чанар шаардлага хангахгүй нөхцөлд уг аргыг ашигладаг. Хамгийн түгээмэл ашиглагддаг төхөөрөмж бол туузан конвейер бөгөөд гараар ялгагч ажилтнууд нэг талаар нь эсвэл 2 талаар нь зогсож ялгалт хийдэг.

Судалгааны үр дүнгээс харахад “Хүдрийн биет 16-2” ордын харьцангуй том ширхэглэлтэй буюу 40мм–ээс дээш ширхэглэлтэй хүдрийг гар аргаар сортлон ялган авч ФК-92, ФК-85, ФК-75 маркийн жоншны баяжмал гарган авах боломжтой .

Баяжуулах технологийн сонголт тооцоо

“Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай жилд 30.0 мян.тн жоншны хүдэр олборлон баяжуулах хэсэгт зөөвөрлөнө. Жонш ангилан ялгах хэсэгт хүдрийг шигшүүр дээр +40 мм-ийн хэсгийг ангилан дараа нь гар аргаар ФК-75-с дээш маркийн жоншийг ялгаж таваарын бүтээгдэхүүний овоолго уруу зөөвөрлөн, үлдсэн -40 мм-ийн ангиллын жоншийг -45% агуулгатайгаар баяжуулах үйлдвэрүүдэд нийлүүлэх бага агуулгатай хүдрийн овоолгод овоолно.



Зураг 2. Ялгалт хийж буй хэсэг.


“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны уурхайн хүдэр баяжуулах технологийн схемийг бусад ижил төстэй ордын адил хамгийн тохиромжтой, энгийн арга болох “хүдрийг гараар ялгах технологи”-ийн схемийг сонгосон. Энэ арга нь эрдсийн өнгө, гялтганах шинж чанар, цацраг идэвхт чанар, гэрлийн ойлт зэрэг шинж чанарын ялгаан дээр үндэслэдэг.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ



“Түшиг Интернэшнл” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
1	Агаар орчин	Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар, агаар дахь тоосны хэмжээ, CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасах, үйлчлүүлэгч, байгууллагын үйлчилгээний автомашины шатах тослох материалын ууршилт, утаа, тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно. Барилга байгууламж байгуулах үеийн газар шорооны ажлаас тоосжилт үүсэх	Төслийн барилгажилтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй, хуурайшилттай үед хучиж бүтээх зэргээр тоос багасгах арга хэмжээ авах	Тоосжилтын эсрэг байнга усалгаа хийх, ногоон байгууламж байгуулах зэрэг ажил явагдлаа.
			Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	2022 онд Хэнтий аймгийн Ус цаг уурын газартай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр хөрс, ус, агаарын шинжилгээнүүдээ хийлгэж байна.
			Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар сард 1 удаа.	
			Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах. Уг багажийг хэрэв БОШТЛ, “ОС МТ” ХХК зэргээс түрээслэвэл түрээсийн зардал нэг удаа 30000 төг	Жилд 1 удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийсэн. Уулын ажлын үед дуу чимээ дунд зэрэг, ажлын өдрүүдээр бага зэрэг болно.

2	Усан орчин		Ус ашиглалтын гэрээг сумын ЗДТГ болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Гэрээ болон төлбөрийн баримтыг хавсралтаар оруулав.
3	Хөрс ургамлан бүрхэвч	Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх, замын нэгдсэн сүлжээг гаргах,	Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах Уурхайн талбайд ашиглагдаж байгаа машины хурдыг 30 км/цаг-аас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах Уурхайн үйл ажиллагааны үед эвдэгдсэн газрыг засч тохижуулах	
4	Амьтны аймаг	Ашиглалтын талбай орчмын амьдрах орчин, амьтдын аюулгүй байдал	Далд уурхайн босоо амруу амьтан орж унахаас сэргийлсэн торон хашаа, хайс байгуулж бүрэн бүтэн байдлыг хангах	

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5	6	7
1.	Техникийн нөхөн сэргээлт	Газрын гадаргыг тэгшхэн бэлчээр болгох, Газрын гадаргыг түрж тэгшилсэн	м2	10000	350	3500.0	
2.	Биологийн нөхөн сэргээлт	<ul style="list-style-type: none"> ➢ Бор-Өндөр сумын Хүйх 5р багийн нутаг цэвэрлэх байгууламжний урд талд 2га газарт "Уул уурхайн төгөл" байгуулахад 2.500.000төг-ний 300ш Хайлаас мод, болон усалгаа, хашаалах ажилд оролцсон. 	Ширхэг	300		2500.0	
		<ul style="list-style-type: none"> ➢ Мөн уурхайн нутаг дэвсгэртээ 1.500.000төг-ний 200ш Хайлаас мод 10ш Улиас мод тарьсан. 	Ширхэг	200		1500.0	

	<p>Нийт</p>					<p>4000.0</p>	<p>Ногоон байгууламжийн ерөнхий төлөвлөгөө</p>  <p> Голт бор Гүйлс Шар хуайс Хайлаас Улиас </p> 
--	-------------	--	--	--	--	---------------	--

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5	6	7	
1.	Төслийн талбайн орчимд уул уурхайн улмаас эвдэрсэн газрыг өөрийн техникээр нөхөн сэргээх	Газрын гадаргыг тэгшхэн бэлчээр болгох	Газрын гадаргыг түрж тэгшлэн биологийн нөхөн сэргээлт хийх				Жилд 1 удаа	Аймгаас байршил өгөөгүй байна. Манай компани байнга албан хүсэлт илгээж байгаа.
	Нийт					3500.0		

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Төслийг хэрэгжүүлэх явцад нүүлгэн шилжүүлэх болон, нөхөн олговор олгох арга хэмжээ хийгдээгүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Ажиллагсадыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвших	Өдөр тутам өмсөж хэвшсэн болно.
2	Галын эрсдэлээс сэргийлэх	Галын эрсдэлээс сэргийлэх тоноглол бэлдэх, сургалт хийх	

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоо нэвтрүүлэх	Хавсралтаар зургийг оруулав.
2	Үйлдвэрийн	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлын ангилан ялгаж, түр хогийн цэгт цуглуулах ба дахин ашиглагдах боломжтой хэсгийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, хог хаягдлыг тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээлэх	

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах МҮ-018936 “Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5	Аюултай	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээлэх	<p align="center">ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ</p> <p align="center">№ 4/5</p> <p>Улаанбаатар хот 2019.04.22</p> <p>Нэг талас <u>Орши Баян Мандал ХХК</u> (цаашид "А" тал гэнэ), түүний төлөөлж <u>У. Цыдып</u> <u>Мөнхбаяр</u> (<u>төлөөлөгч хүний албан тушаал</u>),</p> <p>эцэв/эх-ийн нэр, нэр) Нөгөө талас <u>Аюултай Интернэшнл ХХК</u> (цаашид "Б" тал гэнэ), түүнийг төлөөлж <u>Б. Цыдып</u> <u>Мандал</u> (<u>төлөөлөгч хүний албан тушаал</u>),</p> <p>эцэв/эх-ийн нэр, нэр) Бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.</p> <p align="center">1. Нийтлэг үндэслэл</p> <p>1.1. Гэрээний талууд <u>Аюултай Интернэшнл ХХК</u> <u>Орши Баян Мандал ХХК</u> чиглэлээр <u>А тал - хийгч/хэрэгжүүлэгч</u> хэлбэрээр хамтран ажиллана.</p> <p>1.2. Хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараахь байдлаар харилцан зохион байгуулна (хийх ажлын чиглэл, төрөл, хийгдэх хугацааг заана):</p> <ul style="list-style-type: none"> - "А" тал – Хаягдал түгээх эдийн засаг - "Б" тал – Хаягдал түгээх эдийн засаг нийлүүлэх <p>1.3. Гэрээний хугацаа _____ жил байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.</p> <p align="center">2. Хамтын ажиллагааны удирдлага, хяналт</p> <p>2.1. Энэхүү гэрээний 1.1-д заасан чиглэл хэлбэрийн хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг дараахь журмаар удирдан явуулна:</p> <ul style="list-style-type: none"> - "А" талын "Б" талдаа хамтран <p>2.2. Хамтын үйл ажиллагааг үргэлжлүүлэхтэй холбоотой гарах зардлыг тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.</p> <p>2.3. Хаягдал түгээх эдийн засаг "А" талд нийлүүлэхэд тухайн өдрийн үнээр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.</p> <p align="center">3. Гэрээ хүчин төгөлдөр байх</p> <p>3.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.</p> <p>3.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно):</p> <ul style="list-style-type: none"> - харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно. - аль нэг тал нь _____ сарын өмнө урьдчилан мэдэгдэх замаар гэрээгээс татгалзаж болно. Энэ тохиолдолд тодорхой шалтгаан заагаагүй байж болно. <p>3.3. Талууд тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p>	<p align="center">Талуудын хаяг:</p> <p>А талыг төлөөлж: Орши Баян Мандал ХХК Хаяг: БЗД 1-р хороо 12-р хороолол 28-54 тоот Утас: 96666662 ХХК Гарын үсэг: <u>У. Цыдып</u> (Тамга тэмдэг)</p> <p>Б талыг төлөөлж: Түшиг интернэшнл ХХК Хаяг: <u>Улаанбаатар хот 10-24 нут</u> Утас: <u>96666662</u> Гарын үсэг: <u>Б. Цыдып</u> (Тамга тэмдэг)</p>
---	---------	---	--	---

9. 2022 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Биелэлтийн үр дүн	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар: Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн талбайн автозогсоол	Тоосны хяналт: Төслийн талбайд 1цэгт жилд 3 удаа /хавар, намар, зун/ 1 удаадаа Өдөрт 2 удаа	2022 онд Хэнтий аймгийн Ус цаг уурын газартай хамтран	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах МҮ-018936 “Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар.		Агаарын найрлага: улиралд 1 удаа буюу жилд 3 удаа	ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр хөрс, ус, агаарын шинжилгээнүүдээ хийлгэж байна.	MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
2	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Унд ахуйн усыг хангаж буй төвийн шугамаас хангадаг тул шинжилгээний зардал тусгаагүй болно		Хавсралтаар шинжилгээний бичгүүдийг хавсаргав	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайн хог хаягдлын цэг эсвэл бохирын шугамын холболт хэсэг сонгох	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа, Жилд 1 удаа		MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага

					MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн				1010.0	

10. 2022 ОНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Тухайн жилд аймгийн Засаг даргын өгсөн чиглэлийн дагуу

- 2022 оны Бор-Өндөр сумын "Баяр наадам"-д 3сая төгрөгийн хандив
- Харъяа бр багийн "Өлгий хайрхан" уулын тахилганд 500,000 төгрөгийн хандив тус2 өгсөн.

11. ТУХАН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах хүн	Биелэлтийн үр дүн	Баримтлах хууль, журам, стандарт
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлт батлуулах	Уурхайн дарга	Тайланг хавсаргав.	БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам

12. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧ БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам шинээр батлагдсантай холбогдуулан БОМТ-ны хэрэгжилтийн явцыг хамгаалалтын захиргаа болоод холбогдох төрийн байгууллагуудад дараах хуваарийн дагуу тайлагнахаар төлөвлөв.

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлангах хуваарь

№	Хийгдэх ажил	Тайлагнах хугацаа	Хариуцах хүн	Биелэлтийн үр дүн	Оролцогч талууд
1	БОМТ-ны хэрэгжилт болоод ногоон байгууламжийн ажлын явцтай танилцах	2022.11 сар	Уурхайн дарга	Сумын байгаль орчны байцаагч, орон нутгийн иргэдэд танилцуулав	
2	БОМТ-ний дагуу хийгдсэн ажлыг хүлээлгэн өгөх	2022.11 сар	Уурхайн дарга		
3	БОМТ-ны дагуу хийгдсэн ажлыг тайлагнах	2022.12 сар	Уурхайн дарга	НБОГ БОАЖЯ	